



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 04
сарын 10 өдөр

Дугаар 354
71

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд




У.ХҮРЭЛСҮХ



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 04 дугаар
сарын 04 ны өдөр

Дугаар Хэргийн
664

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Тов тогтоолгох тухай

“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

009873

1513



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018.Ү.Ү № 1-1/1662
танай 2018.Ү.Ү -ны № 4-1/1735 -Т

**САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА**

Таны 2018 оны 4-3/1755 тоот албан бичгээр ирүүлсэн "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Ц.НЯМДОРЖ

08 1053
Doc.yam a5.2017



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018/04/04 № 4-3/1764

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА**

“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.



Хүндэтгэсэн,

Г.ЗАНДАНШАТАР

0 0528

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД




С.ЧИНЗОРИГ

БАТЛАВ
САНГИЙН САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.
ХҮҮЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Ц.НЯМДОРЖ

**ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ
ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монголын нэг өрхийн дундаж орлого нэг сая төгрөг, нийт өрхийн 72.3 хувь нь үүнээс доош орлоготой байна. Нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь 2014 онд 20 хувь байсан бол 2016 онд 29.6 хувь болж 10.0 пунктээр нэмэгдсэн байна. Ядуурлын шугамд ойролцоо байгаа дундаж бүлгийн өрхөд чиглэсэн бодлого хөтөлбөрийг нэмэгдүүлснээр тэднийг ядууралд өртөхөөс хамгаалах боломжтой байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр эдийн засаг сэргэж, тогтворжих төлөв байдал харагдаж байгаа тул хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80 орчим хувьд олгох боломж бий болж байна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл 3 заалттай байх бөгөөд 1 дэх заалтад өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй өрхийн 0-18 насны нийт хүүхдийн 80 хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор, 2 дахь заалтад хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгох, шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийж олгох, 2019 оноос эхлэн жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж байхыг Монгол Улсын Засгийн газарт даалгах, 3 дахь заалтад тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 1.2 дахь дэд заалтыг хүчингүй болсонд тооцох талаар тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хүүхдийн мөнгө нь ядуу өрх, гэр бүлийн хувьд орлогын гол эх үүсвэр болж, өрхийн амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангахад дэмжлэг үзүүлдэг бол дундаж бүлгийн өрхийн хүүхдүүд бүрэн хамрагдсанаар тэдний боловсрол, эрүүл мэнд зэрэг хүүхдийн өсөлт хөгжилтийг хангахад дэмжлэг болохоос гадна мөнгөн хуримтлал үүсгэснээр хүүхдийн цаашдын хөгжилд чухал нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ.

Тогтоолын төсөл батлагдсанаар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80 хувьд олгох тохиолдолд нийт 228.0 мянга орчим хүүхэд нэмэгдэх бөгөөд амьжиргааны түвшний дундаж хэрэглээтэй бүлгийн бүх хүүхэд хамрагдах боломжтой болох юм.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80 хувьд олгоход 41 тэрбум төгрөг нэмж шаардагдах ба үүнийг 2018 оны батлагдсан төсөвт тодотгол хийхгүйгээр шийдвэрлэх боломжтой.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох Монгол Улсын Их Хурлын тогтоол байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг
нэмэгдүүлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн А/15 дугаар тушаалаар *"Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр бэлэн мөнгө хэлбэрээр хүүхдийн мөнгө олгох босго оноог амьжиргааны түвшний үнэлгээний 554 болон түүнээс доош оноогоор тогтоосугай"* гэж заасныг үндэслэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 60 орчим хувь буюу 684.0 мянган хүүхдэд 164.2 тэрбум төгрөг олгохоор баталсан.

Монголын нэг өрхийн дундаж орлого нэг сая төгрөг, нийт өрхийн 72.3% нь үүнээс доош орлоготой байна. Нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь 2014 онд 20% байсан бол 2016 онд 29.6% болж 10.0 пунктээр нэмэгдсэн байна.

Иймд ядуурлын шугамд ойролцоо байгаа дундаж бүлгийн өрхөд чиглэсэн бодлого хөтөлбөрийг нэмэгдүүлснээр тэднийг ядууралд өртөхөөс хамгаалах боломжтой юм. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80%-д олгох тохиолдолд нийт 228.0 мянга орчим хүүхэд нэмэгдэх бөгөөд амьжиргааны түвшний дундаж хэрэглээтэй бүлгийн бүх хүүхэд хамрагдах боломжтой болох юм.

Хүүхдийн мөнгө нь ядуу өрх, гэр бүлийн хувьд орлогын гол эх үүсвэр болж, өрхийн амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангахад дэмжлэг үзүүлдэг бол дундаж бүлгийн өрхийн хүүхдүүд бүрэн хамрагдсанаар тэдний боловсрол, эрүүл мэнд зэрэг хүүхдийн өсөлт хөгжилтийг хангахад дэмжлэг болохоос гадна мөнгөн хуримтлал үүсгэснээр хүүхдийн цаашдын хөгжилд чухал нөлөө үзүүлэх боломж бүрдэх юм.

Хүүхдийн мөнгийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80% олгоход 41 тэрбум төгрөг нэмж шаардагдах ба үүнийг 2018 оны батлагдсан төсөвт тодотгол хийхгүйгээр шийдвэрлэх боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны .. дугаар
сарын..-ны өдөр

Улаанбаатар
хот

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй өрхийн 0-18 насны нийт хүүхдийн 80 хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор тогтсугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийж олгох, 2019 оноос эхлэн жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХАМРАХ
ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС**

№	Нэр	Албан тушаал
1	Ч.Хүрэлбаатар	Сангийн сайд
2	С.Чинзориг	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
3	Х.Булгантуяа	Сангийн дэд сайд
4	С.Наранцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
5	Г.Өнөрбаяр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
6	Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
7	Л.Мөнзул	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
8	Д.Гэрэлтуяа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
9	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн мэргэжилтэн
10	Э.Номин-Эрдэнэ	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн мэргэжилтэн